

ХҮНД НӨХЦӨЛ ДЭХ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АГУУЛГА, ХЭЛБЭР, ХҮРТЭЭМЖ

*А. Батхишиг
Нийгмийн ажлын доктор (Ph.D)*

/ХИС (Англи)-ийн Хүүхдийн хамгаалал хөтөлбөрийн жишээ/

Энэ өгүүлэлд Хүүхдийг Ивээх Сан /Англи/-гийн Хүүхдийн хамгаалал хөтөлбөрийн үндсэн хэсэг болох хараа хяналтгүй хүүхэд төслийн халамжийн төв, өдрийн үйлчилгээний төв, мөн олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил хамгааллын төвөөс үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний агуулга, хэлбэр, хүртээмжийн байдалд хийсэн дүн шинжилгээний талаар өгүүлэх болно. Чингэхдээ төвүүдэд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээг Филиппиний хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн цогц хөтөлбөртэй харьцуулан үзэж, нийгмийн ажлын үйлчилгээг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн цаашид хэрхэн хөгжүүлэх тухай саналыг дэвшүүлжээ. Уг өгүүллийг бичихдээ ХИС ба бусад байгууллагын үйл ажиллагааны тайлан, бодлогын баримт бичиг, хөтөлбөр ба төслийн үнэлгээ, судалгаа, холбогдох онолын материалыг эргэн харах, харьцуулан дүгнэх замаар чанарын судалгааны зарим аргыг ашигласан.

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн Хараа хяналтгүй хүүхэд төслийн тухай 1994 онд Монголд үйл ажиллагаагаа эхэлсэн Хүүхдийг Ивээх Сан /Англи/ нь хөгжлийн чиг хандлагатай, хүүхдийн эрхэнд суурилсан үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд эрх нь ноцтой зөрчигдсэн хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн бие даасан төслийг 1996 оноос хойш хэрэгжүүлж ирсэн. Энэ төслийн хүрээнд 1996- 1998 онд хараа хяналтгүй хүүхдийг түр байрлуулах халамжийн төвүүдийг Улаанбаатар хот, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад байгуулсан. Мөн гэр орноосоо дайжсан, гудамжинд амьдарч буй хүүхдүүдэд зориулсан өдрийн үйлчилгээний төвүүдийг Улаанбаатар хот ба Дорнод аймагт нээсэн юм.

2001 оноос орон нутгийн хүүхдийн байгууллагын үүргийг нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх зорилгоор халамжийн төвүүдийг орон нутгийн засаг захиргааны мэдэлд шилжүүлж эхэлсэн. 2003 оноос хараа хяналтгүй хүүхдийн халамжийн төвийн үйл ажиллагааг өөрчлөн, хараа хяналтгүй хүүхэд болохоос урьдчилан сэргийлэх, хүнд нөхцөлд амьдарч, сурч байгаа хүүхдэд үйлчлэх олон нийтэд түшиглэсэн Хүүхдийн хөгжил хамгааллын төв байгуулж эхэлсэн. Өнөөдөр ХИС-ийн дэмжлэгээр Улаанбаатар хотод халамжийн гурван төв, хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн өдрийн үйлчилгээний нэг төв, олон нийтэд түшиглэсэн нэг төв, Дорнод аймагт халамжийн нэг төв, олон нийтэд түшиглэсэн нэг төв үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн ХИС-ийн дэмжлэгээр Сэлэнгэ аймгийн Хүүхдийн төлөө төв болон Монголын Хүүхдийн эрхийн төв /МХЭТ/-ийн Дархан- Уул аймаг дахь салбар нь Сэлэнгэ, Дархан-Уул аймагт халамжийн төвүүдийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

ХИС нь нийгмийн ажлын боловсролыг хөгжүүлэх хөтөлбөрийг УБИС-тай хамтран анх хэрэгжүүлсэн, нийгмийн ажлын сургалт, практик үйл ажиллагааны талаар багагүй туршлага хуримтлуулсан байгууллагын хувьд төслийн ажилтнуудад зориулсан шаталсан сургалтуудыг Нийгмийн ажлын тэнхимтэй хамтран зохион байгуулж, төвийн багш, ажилтнуудад хүүхдийн халамж хамгааллын салбарт ажиллах нийгмийн ажилтны мэргэжлийн үнэмлэх олгосон. Мөн 2001 оноос УБИС-ийн нийгмийн ажлын бакалаврийн анхны ангийг дүүргэсэн дөрвөн нийгмийн ажилтанг хүнд нөхцөл дэх хүүхэдтэй ажиллах нийгмийн ажилтнаар ажиллуулж эхэллээ. Ийнхүү нийгмийн ажлын тусгай сургалтад сурч бэлтгэгдсэн багш, менежерүүд нийгмийн ажлын бакалавр ажилтнуудтай хамтран хүүхдийн халамжийн төв, өдрийн үйлчилгээний төв, олон нийтэд түшиглэсэн төвүүд дээр төрөл бүрийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг. Хөтөлбөрийн хүрээнд нийгмийн ажилтан, төвийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах

зорилгоор нийгмийн ажилтан төвийн менежерүүдийн дунд тодорхой кейс, төвөгтэй асуудлыг зөвлөлдөх уулзалт “кейс конференци”-ыг, мөн мэргэжлийн удирдлагаар /supervision session/ хангах цуврал уулзалтуудыг нийгмийн ажлын өндөр боловсрол, туршлагатай гадаад дотоодын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг.

1. Хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээний агуулга, хэлбэр, хүртээмж

Хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн халамж хамгааллын хөтөлбөрийг дараах гурван хэлбэрт хуваадаг²⁶⁶. Үүнд: а) төвд түшиглэсэн хөтөлбөр; б) ажиллаж амьдарч байгаа газарт нь буюу гудамжинд хүрч үйлчлэх хөтөлбөр; в) олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр гэж хуваана. Эдгээр хөтөлбөрийг хараа хяналтгүй хүүхдийн гэр бүлтэйгээ харилцаа холбоотой байгаа эсэхээс хамаарч ерөнхийд нь гурван бүлэг болгодог. Хараа хяналтгүй хүүхдүүдийг бүлэглэсэн олон янзын ангилал байдаг ч ерөнхийд нь дараах гурван бүлэгт хувааж болно. Үүнд: нэгдүгээр бүлэгт гэр бүлтэйгээ байнгын холбоотой боловч ихэнх цагаа гудамжинд өнгөрөөдөг, хоёрдугаар бүлэгт гудамжинд амьдарч ажилладаг, гэр орноосоо дайжсан, гуравдугаар бүлэгт эцэг эх, гэр бүлийнхэнтэйгээ гудамжинд амьдардаг хүүхдүүд хамрагддаг байна²⁶⁷.

ХИС-ийн Хүүхэд хамгаалал хөтөлбөрийн хувьд халамжийн төвд түшиглэсэн үйлчилгээ, гудамжинд байгаа хүүхдэд үйлчлэх өдрийн төвийн үйлчилгээ болон олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил хамгааллын төвүүдээрээ дамжуулж төрөл бүрийн нийгмийн үйлчилгээг үйлчлүүлэгчдээ санал болгодог. Дээрх төвүүдэд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний агуулга, хэлбэр, хүртээмж нь төвийн үйлчлэх хүрээ, зорилтот бүлэг, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, тэдэнд тулгарах бэрхшээлтэй асуудал зэргээс улбаалан ялгаатай байна.

Халамжийн төвд түшиглэсэн үйлчилгээ: Хүүхдийн амьдрах, хамгаалуулах, хөгжих эрх нь гэр бүлдээ хамгийн найдвартай хамгаалагддаг тул хүүхэд бүр гэр бүлийн орчинд өсөх эрхтэй гэдэг үзлийг ХИС баримталдаг ч энэ эрх нь хэрэгжих нөхцөлгүй хүүхдэд зайлшгүй шаардлагатай үед, ялангуяа хүүхдийн амь насанд нь шууд аюултай нөхцөлд л хүүхдийг гэр бүлээс нь тусдаа халамжлах үйлчилгээг гардан эрхэлнэ²⁶⁸ гэсэн бодлогыг баримталдаг. Энэ бодлогын хүрээнд гэр орноосоо дайжсан, эцэг эхээсээ холбоо тасарсан ба гэртээ очих боломжгүй хараа хяналтгүй хүүхдэд түүний хүсэл сонирхлыг харгалзан ба нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн халамжийн төвд байрлуулан, төвд түшиглэсэн төрөл бүрийн дараах үйлчилгээг санал болгоно. Үүнд: а) Хүүхэд бүрийн хэрэгцээ сонирхлыг судалж, нас биед нь тохирсон хүүхдийг хөгжүүлэх

төлөвлөгөө гаргах

- б) Хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хангах, хүчирхийлэл дарамтаас хамгаалах, урьдчилан хамгаалах
- в) Албан ба албан бус сургалтанд хамруулах,
- г) Хүүхэд хөгжүүлэх ба нийгэмшүүлэх төсөл хөтөлбөрт хамруулах
- д) Гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, гэр бүлтэй нь холбоо тогтооход туслах зэрэг үйлчилгээ үзүүлнэ.

2000-2003 онд ХИС-ийн Улаанбаатар хот болон Дорнод аймаг дахь долоон халамжийн төвд нийт 814 хүүхэд (давхардсан тоогоор) үйлчлүүлж, энэ хугацаандаа 120 хүүхэд төрсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхтэй болжээ. Мөн 344 хүүхэд албан сургалтанд, 82 хүүхэд албан бус сургалтанд хамрагдан суурь болон бүрэн дунд боловсролтой, 58 хүүхэд сонирхлын дагуу мэргэжлийн сургалтанд хамрагдаж, мэргэжилтэй болсон байна. Хүүхдийг нийгэмшүүлэх ба хөгжүүлэх цирк, видео, цирк төсөл хөтөлбөрт нийт 100 гаруй хүүхэд хамрагдсан. 2000-2003 онд халамжийн төвөөс 172 хүүхэд гэртээ буцсанаас 2003 онд гэртээ буцсан 53 хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ зохих ёсоор мэргэжлийн түвшинд хийгдсэн байна.

266 Programme Development for Street Children, Philippines Country Paper (2003), A Regional Civil Society Forum for South and East Asia on Promoting and Protecting the Rights Street Children, Thailand, p 9

267 “Children in Distress” Ibon Fact & Figures, June 30, 2001, Vol 24, No 11,3

268 “Эцсийн арга хэмжээ: Халамж асрамжийн газар хүмүүжиж буй хүүхдүүдийн талаар улам түгшихүй”, Халамж асрамжийн газруудын талаар Хүүхдийг ивээх сангийн баримтлах байр суурь., Хүүхдийг ивээх сангуудын эвсэл

Ерөнхийдөө халамжийн төвд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээ нь боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжил ба нийгэмшүүлэх асуудалд илүү анхаарч, бусад нийгмийн үйлчилгээний байгууллагатай тухайлбал, эмнэлэг, сургууль, орон нутгийн засаг захиргаагаар нягт холбоотой ажилладаг байна. Үйлчилгээний хүртээмжийн хувьд нэг халамжийн төв нь 20-25 хүүхдэд үйлчлэх хүчин чадалтай бөгөөд хүүхэд гэр бүлдээ буцах боломжтой болох, хууль ёсны асран хамгаалагчийг олж тогтоох эсвэл бие даан амьдрах чадвартай болтол хүүхдүүд төвд амьдардаг. 2003 оноос гэр бүлд буцаах бодлогыг баримталж, гэр бүлийг дэмжих эрчимтэй бодлого баримталсны үр дүнд хүүхдийн төвд амьдрах хугацаа богиносх хандлагатай байна. 2002-2003 онд төвд хүүхдийн амьдрах дундаж хугацаа 5-6 жил байсан бол одоо 4-5 жил боллоо.

Өдрийн төвд түшиглэсэн үйлчилгээний тоонд гудамжинд байнга ажиллаж, амьдарч буй хүүхдэд хүрч үйлчлэх ба өдрийн төвд түшиглэсэн суурь үйлчилгээ (халуун усанд орох ба хувцсаа угаах ба хооллох) ба нийгмийн ажлын үйлчилгээ багтана. Тус төв дээр нийгмийн ажилтнууд бусад төслийн ажилтнуудтай хамтран дараах үйлчилгээг үзүүлдэг: Үүнд:

- а) Анхны ярилцлага ба уулзалт хийх,
- б) Зөвлөгөө өгөх,
- в) Албан бус сургалтанд хамруулах,
- г) Хөгжлийн болон нийгэмшүүлэх төсөл хөтөлбөрт хамруулах,

д) Бусад шаардлагатай үйлчилгээтэй холбох зэрэг үйлчилгээг хамруулдаг. 2000-2003 онд өдрийн төвийн төрөл бүрийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоог нэгтгэн дүгнэвэл : 284 хүүхдэд нийгмийн ажлын төрөл бүрийн үйлчилгээ үзүүлснээс гудамжинд ажиллаж амьдарч буй 238 хүүхдийг амьдарч ажиллаж буй газар нь амьдрах ухааны сургалтанд хамруулж, 17 хүүхдийг иргэний бичиг баримттай болоход туслан, 152 хүүхдийг халамжийн төвд шилжүүлэн, цөөн тооны хүүхдийг гэр бүлд нь буцаасан байна. Мөн 8 хүүхэд албан бус сургалтанд хамрагдаж, 25 хүүхэд тус төв дээр цирк болон театрийн дугуйланд хамрагджээ. Үйлчилгээний хүртээмжийн хувьд тус төв өдөрт 25 хүүхдэд суурь үйлчилгээ (хооллох ба усанд орох) үзүүлэх хүчин чадалтай бөгөөд жилд дундажаар 4000 орчим (давхардсан тоогоор) хүүхдэд суурь үйлчилгээ ба нийгмийн ажлын болон бусад үйлчилгээг үзүүлдэг.

Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил хамгааллын төвийн олон нийттэй ажиллах ба хувь хүнтэй ажиллах нийгмийн ажилтнууд, сургагч багш, туслах ажилтнууд байрлаж буй нутаг дэвсгэрийнхээ хүүхдүүд, эцэг эх, хүүхдийн төлөө ажилладаг байгууллага, хүмүүст дараах нийгмийн ажлын ба хөгжлийн үйл ажиллагааг үзүүлдэг. Үүнд:

- а) Хүүхдийн хамгаалал, хөгжлийн талаар зөвлөгөө өгөх, сургалт явуулах,
- б) Мэдээлэл болон номын сангаар үйлчлэх,
- в) Хүчирхийлэл дарамтанд өртсөн хүүхэд, эцэг эхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх,
- г) Хүүхдийн хамгааллын чиглэлээр орон нутгийн холбогдох байгууллагатай хамтран ажиллах, тэдний чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн ажил, үйлчилгээ явуулдаг.

Энэ төвийн өмнөх хоёр төвөөс ялгагдах онцлог нь зөвхөн эмзэг бүлгийн хүүхэд, эцэг эхэд гэж үйлчилгээг хязгаарлалгүй, оршин байгаа нутаг дэвсгэрийн хүүхдүүд, тэдний эцэг эхэд хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хамгаалал, эрхийн асуудлаар орон нутгийн хүчийг дайчлах, орон нутгийн чадавхийг бэхжүүлэхийг зорьж байгаад оршино. Олон нийтэд үйлчлэх төв нь 2003 оны 12 сард байгуулагдсан хэдий ч өнгөрсөн гурван сарын хугацаанд 421 хүүхдэд номын сан, сургалт, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, хөгжүүлэх дугуйлан секцэнд хамруулах үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн 13 хүүхэдтэй ганцаарчлан ажиллаж, хүүхэд болон тэдний гэх бүлийг бусад үйлчилгээ нөөцтэй холбожээ. Эдгээр үзүүлэлт нь олон нийтэд үйлчлэх төв бусад төвүүдээс илүү өргөн хүрээтэй хүртээмжтэй үйлчилгээ явуулж болохыг харуулж байна.

2. ХИС-ийн хараа хяналтгүй хүүхдэд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээг Филиппиний цогц үйлчилгээний загвартай харьцуулах нь

ХИС-ийн халамжийн төв, өдрийн үйлчилгээний төв болон олон нийтэд түшиглэсэн төвүүдэд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний агуулга, хэлбэрийг Филиппиний туршлагатай, тодруулбал Филиппин улсын Азийн хүүхдийн найдвар гэдэг ТББ-аас гаргасан хараа хяналтгүй хүүхдэд үйлчлэх цогц үйлчилгээний загвартай харьцуулан авч үзье. ХИС-ийн хөтөлбөрийн ажилтнууд төслийг боловсруулах ба хэрэгжүүлэх явцдаа Филиппиний Азийн Хүүхдийн найдвар ТББ-ийн удирдлагатай уулзаж, харилцан туршлага солилцож, хараа хяналтгүй хүүхдэд үйлчлэх цогц загварыг төсөлдөө нэвтрүүлж, үйл ажиллагаанд тусгасан юм. Хэдийгээр Филиппиний загвар болон ХИС-ийн загвар тус бүрийг энэ удаад нарийвчлан задлан шинжилж судлаагүй ч үйлчилгээний үндсэн чиглэл, агуулга, хэлбэрийг эмпирик түвшинд харьцуулан үзсэн юм. Жишээ нь халамжийн төвд үзүүлж буй анхны уулзалт ярилцлага хийх, төвд хүлээн авах ба шинэ орчинд дасгах, албан ба албан сургалтанд хамруулан боловсролтой болгох, мэргэжлийн сургалтанд хамруулах, бусад үйлчилгээ, хөгжлийн болон нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, гэр бүлтэй нь нэгтгэх зэрэг ажил нь ХИС-ийн халамжийн төвийн үйл ажиллагааны үндсэн хэсэг болж чаджээ. Харин нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, кейс менежмент, байнгын асран хамгаалагч “хуурай” эцэг эхтэй болоход туслах, бие даан бүлгээр болон ганцаараа амьдрахад туслах зэрэг үйлчилгээ нь манай халамжийн төвүүдэд хараахан хөгжөөгүй. Энэ нь, эдгээр үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлж дүгнэх талаар төслийн ажилтнууд хангалттай бэлтгэгдэж чадаагүй, кейс менежментийн тухай ойлголт, практик шинэ, түүнчлэн цусан төрлийн бус, хууль ёсны “хуурай” аав ээжийн асрамжинд байх зэрэг практик нь хараахан дүрэм журмаар зохицуулагдаагүй байгаатай холбоотой байж болох юм.

Филиппиний Ази хүүхдийн найдвар ТББ-ийн боловсруулсан загварт гудамжинд байнга ажиллаж амьдарч буй хүүхдэд өдрийн төвд түшиглэсэн үйлчилгээ, мөн гудамжинд нь хүрч үйлчлэх үйлчилгээ чухал байр суурийг эзэлдэг. ХИС-ийн Хараа хяналтгүй хүүхдийн төслийг үнэлсэн үнэлгээнд ч өдрийн төвийн үйл ажиллагааг хараа хяналтгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээний төвд тавьж хөгжлийн чиг хандлагатай болгох, хүүхдийг гудамжнаас гэрт нь эрт буцаах үйл явцыг дэмжих зэрэг зөвлөмжүүдийг санал болгосон байна.²⁶⁹ ХИС нь дээрх үнэлгээний зөвлөмж болон бусад орны туршлагаас суралцан өдрийн төвийн үйл ажиллагааг хөгжлийн төв болгох ажлыг 2003 оноос эхлэн эрчимтэй хийж төвийн үйлчилгээнд нийгмийн ажлын үйлчилгээ зохих байр суурь эзэлж чадсан байна. Гэвч гудамжинд амьдарч буй хүүхдэд хүрч үйлчлэх, гэр бүлтэй нь холбоо тогтоох ба гэртээ эргэн нэгтгэхэд нь туслах, боловсролтой болгох, мэргэжлийн сургалтанд хамруулах, хорт болон буруу зуршил, дадлаас нь салгах ажилд нэлээд хүндрэл учирч, амжилттай сайн хийгдэж чадаагүй байна.

Олон нийтэд түшиглэсэн хүүхэд хөгжил хамгааллын төвийн хувьд Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах ажилд илүү их анхаарч, орон нутгийн иргэд, олон нийтийн анхаарлыг хүүхдийн хөгжил хамгааллын асуудалд хандуулах ажлуудыг хийж эхэлсэн байна. Монголын нөхцөлд туршин хэрэгжүүлж буй олон нийтэд үйлчлэх төвийн анхны энэ загвар нь тухайн сонгосон орон нутгийн нийт хүүхдүүдэд үйлчлэх, улмаар гэр орноосоо дайжих, сургууль завсардах эрсдэлд байгаа болон хүчирхийлэл дарамтанд буй хүүхдийг хамгаалах, урьчилан сэргийлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй үйлчилгээг санал болгож байгаагаараа Филиппиний загвараас ялгаатай юм. Харин Филиппиний цогц хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн хүүхдэд тулгамдсан асуудлуудаас нэн тэргүүнд хийх асуудлыг тодорхойлох, орон нутгийн хүчийг дайчлах, чадавхижуулах ажлууд шинэ тулгар хөгжиж буй олон нийтэд түшиглэсэн төвийн хувьд дөнгөж эхлэл буюу бэлтгэл үе шатандаа байна.

3. Нийгмийн хөгжлийн чиг хандлагыг хүнд нөхцөл дэх хүүхэдтэй ажиллах нийгмийн ажлын практикт баримтлахад тулгарах асуудлууд

Жеймс Миджлейгийн тодорхойлсноор нийгмийн хөгжил нь нийгмийн бодлогыг эдийн засгийг дэмжих бодлоготой зөв хослуулахыг зорьдог. Бусад нийгмийн халамж болон хүмүүсийн

269 Ч. Тунгалаг, Анди Вест, 2002, Хараа хяналтгүй хүүхэд төслийн үнэлгээ, ХИС (Англи), 47-48х

сайн сайхан байдлыг дэмждэг филантрофи, нийгмийн ажил, нийгмийн удирдлага зэрэг салбар, урсгал чиглэлээс нийгмийн хөгжлийн чиг хандлагын ялгагдах онцлог нь хөгжлийн үйл явцыг дэмжсэн нийгмийн болон эдийн засгийн зорилтуудыг өргөн хүрээнд уялдуулахад анхаардаг²⁷⁰. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь нийгмийн хөгжлийг хүний тогтвортой хөгжилтэй адилтгасан бөгөөд хүний сонголт хийх боломж, чадварыг нэмэгдүүлэх хүчин чармайлтанд ач холбогдол өгдөг. Харин Паул Стриитин (1992) нийгмийн хөгжлийг гурван талт үйл явц гэж үзсэн. Эдгээр гурван талт үйл явцад, нэгдүгээрт нийгмийн үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол), нийгмийн аюулгүй байдал ба аюулгүй байдлыг хангах тогтолцоо, хоёрдугаарт эдийн засгийн үр шимийг хүртэх ба эргэн төлөгдөх боломж нөхцлөөр хангах (өрхийн орлого нэмэгдүүлэх, аюулгүй, найдвартай хөлсний ажилтай болгох хөтөлбөр), гуравдугаарт нийгэмдээ болон орчиндоо өөрийн байр сууриа олох, бусадтай холбоотой байх ба эвлэлдэн нэгдэх (энх тайван, хүчирхийлэлгүй байх) зэрэг үйл явцыг тус тус багтаажээ.

Энэхүү нийгмийн хөгжлийн үйл явц нь зөвхөн материаллаг, таваарлаг хүчин зүйлсээр тодорхойлогддоггүй бөгөөд асуудлыг цогц байдлаар нь авч үзэхийг чухалчилдаг байна. Материаллаг болон нийгэм сэтгэл зүйн сайн сайхан байдал, улс төрийн эрүүл уур амьсгал, эв нэгдэл, эерэг тогтвортой харилцаа холбоо зэрэг нийгмийн хөгжлийг бүхэлд нь тодорхойлох чухал хүчин зүйлүүд юм²⁷¹. Энэ бүгдээс үзэхэд хүнд нөхцөл дэх хүүхдэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг цогц байдлаар нь хүүхэд, гэр бүл, олон нийтийг дэмжих, хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нийгмийн бодлогыг түүнийг дэмжих эдийн засгийн сайн бодлоготой холбоход анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Нийгмийн хөгжлийн чиг хандлагад тулгуурласан үр дүнтэй нийгмийн бодлого нь тогтвортой улс төрийн орчин, хариуцлагатай засгийн газар, тэгш байдлыг дээдэлсэн нийгмийн үнэт зүйлсийг шаарддаг²⁷². Өнөөдөр Монголын улс төрийн байдал харьцангуй тогтвортой байгаа хэдий ч хүн бүр нийгмийн баялгаас тэгш хүртэх боломж улам багасч, хүмүүсийн амьдралын түвшин эрс ялгаатай болсоор байна. Энэ байдал хүүхдэд, тэр дундаа хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдэд улам хүндээр тусч байгааг олон судлаачид судалсан байдаг. Нөгөө талаар хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн халамж хамгааллын ихэнх үйлчилгээг тодруулбал халамжийн төвд ба гудамжинд хүрч үйлчлэх үйлчилгээг гадаадын болон дотоодын ТББ-ууд голлон хүргэж байна.²⁷³ Энэ байдалд хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд дүгнэлт хийж дотоодын байгууллага, иргэдийн хүч анхаарлыг хандуулах төрийн бодлого баримталж байгаа хэдий ч энэ нь бодит байдал дээр тэр бүр хэрэгжихгүй байна. Мөн хараа хяналтгүй хүүхдэд, ер нь хүнд нөхцөл дэх хүүхдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг удирдан зохицуулах төрийн бодлого, журам байхгүйгээс салбарт ажиллаж буй байгууллага, бүлэг, хувь хүмүүс өөрсдийн зөв, чухал гэсэн арга замаар хүүхдэд халамж хамгааллын үйлчилгээг үзүүлж байна.

ХИС-ийн одоо үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээг жишээ болгон хүнд нөхцөл дэх хүүхдэд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээг хэрхэн нийгмийн хөгжлийн чиг хандлагатай болгож болох талаар авч үзье. Жеймс Миджлейгийн тодорхойлсноор нийгмийн сайн сайхан байдлыг хангахад дараах үндсэн гурван нөхцлийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулж үйлчилгээг цогцоор нь авч үзэх ёстой. Үүнд: нийгмийн асуудлыг зохистой байдлаар удирдан зохицуулах, нийгмийн үйлчилгээг хэрэгцээнд нь нийцүүлэх ба хүмүүсийн боломж чадавхийг нэмэгдүүлэх зэрэг нөхцлүүд багтдаг.

Халамжийн, өдрийн үйлчилгээний болон олон нийтэд түшиглэсэн төвүүдийн хувьд үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээг үр дүнтэй удирдан зохицуулахад зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагыг үзүүлж буй үйлчилгээнийхээ зорилго чиглэл, агуулга, хэлбэр, цар хүрээтэй зохистой уялдуулах хэрэгтэй болж байна. Аль ч төвд үзүүлж буй нийгмийн

270 Midgley, J (1995) Social Development, The Development Perspective in Social Welfare, London: Sage p1

271 Lance Taylor, Santosh Mehrotra & Enrique Delamonica, The Links between Economic Growth, Poverty Reduction and Social Development: Theory and Practice.

272 Ibid, p423

273 Монгол дахь хараа хяналтгүй хүүхэд

ажлын үйлчилгээ нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах хүүхдэд болон тэдний гэр бүлд тулгарсан асуудлыг шийдэхэд туслахуйц байхаар зохицуулах хэрэгтэй байна.

Хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцлийн хувьд ХИС-ийн төвүүд нь үйлчлүүлэгчийн хэрэгцээг хүндэтгэн түүнд чиглэсэн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн эрхийг бодит болгоход шаардлагатай үйл ажиллагаа, үйлчилгээг зайлшгүй үзүүлэх шаардлагатай болно. Энэ тохиолдолд эрхэнд тулгуурласан хандлага ба хэрэгцээнд тулгуурласан хандлагыг хэрхэн тэнцвэртэй баримтлах вэ гэдэг асуудал тулгарч байна.

Хүмүүс нөөц, боломжоо дээд зэргээр ашиглах, бодит болгох боломжийг бий болгох нөхцлийг хангахын тулд халамжийн төв, өдрийн үйлчилгээний төв, олон нийтэд түшиглэсэн хүүхдийн халамж хамгааллын төвүүд түүний тулгамдсан хэрэгцээг хангах халамж асрамжийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгчийг чадавхижуулах, нөөц боломжоо илрүүлэхэд нь туслах, гэр бүл, орон нутгийн хүүхдийг дэмжих, хамгаалах тогтолцоог бий болгоход чиглэсэн төрөл бүрийн хамгаалах, урьдчилан сэргийлэх, нөлөөлөх үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах хэрэгтэй болж байна.